

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	8
3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	8
3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	9
3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	10
3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2020.03.13 № 06/778  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

“Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус төсөлд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

“Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч Н.Баяртогтох Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Улаанбаатар хотын цэвэр агаар” төсөл нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 20-ноос 2020 оны 02 дугаар сарын 27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төслийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Нийслэл аудит” ХХК-ийн аудитор Т.Сугарсүрэн, шинжээч Д.Доржпүрэв нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн удирдлага 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 06 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Улаанбаатар хотод агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төслүүдийн уялдаа холбоог сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх, үйл ажиллагааг

давхардуулахгүй байх, өмнө хийгдсэн ажлуудын алдаа оноог үнэлж, цэгнэх, гарсан сургамж дээр үндэслэн үндэсний хэмжээний бодлогыг боловсруулахад оршино.

Төсөл нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ:

*Бүрэлдэхүүн хэсэг 1:*

Гэр хорооллын орчинд нарийн ширхэгт тоосонцорын агууламжийг бууруулахын тулд сайжруулсан зуухны хөтөлбөр хэрэгжүүлэх;

*Бүрэлдэхүүн хэсэг 2:*

Улаанбаатар хотын төвийн бүсэд нарийн ширхэгт тоосонцорын агууламжийг багасгах зорилгоор үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэх болон тэргүүлэх ач холбогдол бүхий бодлогын зөвлөмжүүд боловсруулах;

*Бүрэлдэхүүн хэсэг 3:*

Олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, хөтөлбөрийн уялдаа холбоог хангах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус төслийн Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа Дэлхийн банкнаас гаргасан төсөл хэрэгжүүлэх заавар нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Улаанбаатар хотын цэвэр агаар” төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “DSAP” программ хангамж ашигладаг байна.

“Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар “Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 4 эрсдэлтэй асуудалд 4 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитын гүйцэтгэлийн үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,601,617.3 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 52,032.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшингийн 52,032.3 мянган төгрөгөөр тогтоосон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож төслийн зээлийг үр ашигтай зарцуулж байгаа эсэхийг шалгах шаардлагатай гэж үзсэнтэй холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 601,521.9 мянган төгрөгөөр буюу 40.2 хувиар буурсан нь 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр төсөл хаагдах байсан боловч гэрээ сунгагдаж 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хаагдах болсонтой холбоотой.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	960,677.3	368,496.6	(592,180.7)
Үндсэн хөрөнгө	45,801.3	36,460.1	(9,341.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,006,478.6</b>	<b>404,956.7</b>	<b>(601,521.9)</b>
Бусад өглөг		2,733.3	2,733.3
<b>Нийт өр төлбөр</b>		<b>2,733.3</b>	<b>2,733.3</b>
Хуримтлагдсан үр дүн	1,006,478.6	402,223.4	(604,255.2)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,006,478.6</b>	<b>404,956.7</b>	<b>(601,521.9)</b>

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9,341.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардал өссөнөөс шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 404,956.7 мянган төгрөг болж 601,521.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагаанд зориулан 3,505,549.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 2,592,276.1 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Нийт зардлын 1,986,039.4 мянган төгрөгийг Олон улсын ассоциацийн хөнгөлөлттэй зээлээр, 7,208.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлээс 2,460.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 68,023.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад төлбөр 55,114.9 мянган төгрөг, хөрөнгийн зардал 787,674.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 913,273.4 мянган төгрөг буюу 73.9 хувьтай байгаа нь төсөл 2019 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хаагдаж төслийн 2 дугаар шат эхлэх байсан боловч төсөл хэрэгжих хугацааг жилийн эцэс болтол хойшлуулсантай холбоотой байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 4 эрсдэл, 4 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар 2,733.3 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

1. Хаан банкны (5926115925) тоот дэд дансны үлдэгдэл 1,000.0 ам.долларыг шилжүүлэхдээ банкны ажилтан 1,000.0 ам.доллар илүү шилжүүлсэн байна. Дээрх гүйлгээг төгрөгт хөрвүүлэн 2,733.3 мянган төгрөгийг санхүүгийн тайланд бусад орлогоор тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр төсөл хаагдаж байгаа бөгөөд аудитаар үйл ажиллагааны орлого, зарлага, цалингийн зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоолол, ангилал, тайлант онд худалдан авсан бараа ажил үйлчилгээ, зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт, анхан шатны баримтын хүчин төгөлдөр байдлыг бүрэн шалгасан бөгөөд анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

“Улаанбаатар хотын цэвэр агаар” төсөл Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 75 мэдээллийг хугацаанд нь, 20 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгөгдсөн бөгөөд зөвлөмжийг бүрэн биелүүлсэн байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид “Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### **“Зөрчилгүй” дүгнэлт**

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг хэмжээний алдаа илрээгүй тул “Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



### 3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

#### 3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>960,677,339.77</b>	<b>368,496,603.90</b>
<b>31</b>	<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө</b>	<b>960,677,339.77</b>	<b>368,496,603.90</b>
31210	Банкид байгаа бэлэн мөнгө /долларын данс/ Улаанбаатар хотын банк	953,555,730.77	233,195,552.46
31211	Банкинд байгаа бэлэн мөнгө /Төрийн сан Хөрөнгө оруулалтын данс/		95,974,216.00
31212	Банкинд байгаа бэлэн мөнгө /Төрийн сан Үйл ажиллагааны данс/	7,121,609.00	39,326,835.44
<b>2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		
<b>39</b>	<b>Үндсэн хөрөнгө</b>	<b>45,801,273.60</b>	<b>36,460,077.07</b>
39201	Барилга байгууламж		
39202	Хуримтлагдсан элэгдэл		
39203	Авто-тээврийн хэрэгсэл	97,000,000.00	97,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(61,962,222.22)	(69,237,222.22)
39205	Машин, тоног төхөөрөмж	30,670,618.45	30,670,618.45
39206	Хуримтлагдсан элэгдэл	(30,670,618.45)	(30,670,618.45)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,950,719.92	32,950,719.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,187,224.10)	(24,253,420.00)
39301	Программ хангамж		
39302	Хуримтлагдсан элэгдэл		
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,006,478,613.37</b>	<b>404,956,681.60</b>
<b>41</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		<b>2,733,280.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>		
41360	Бусад өглөг		2,733,280.00
	<b>УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН</b>		
	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>		<b>2,733,280.00</b>
51100	Засгийн газрын хувь оролцоо		
51101	Хуримтлагдсан үр дүн	1,006,478,613.37	402,223,401.60
51210	Өмнөх үеийн үр дүн	1,746,580,074.28	1,006,478,613.37
51220	Тайлант үеийн үр дүн	(740,101,460.91)	(604,255,211.77)
51300	Дахин үнэлгээний нэмэгдэл		
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>		
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,006,478,613.37</b>	<b>404,956,681.60</b>

### 3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>		<b>1,993,562,349.49</b>
120001	Улсын төсвөөс		
120002	НӨТ-ын хөнгөлөлт		
120003	Зээлийн хөрөнгийн эх үүсвэрээс олгосон санхүүжилтийн орлого	3,035,188,495.64	1,986,039,395.22
120002	Хүүгийн орлого		7,207,954.27
	Бусад орлого	11,864,433.48	
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		315,000.00
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>1,993,562,349.49</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>		
	<b>Бусад бараа үйлчилгээний зардал</b>		
	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>359,516,616.26</b>	<b>275,487,944.63</b>
210401	Цалин	320,945,630.26	220,950,925.77
210402	Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	38,570,986.00	54,537,018.86
210403	Тогтмол зардал		
210404	Гэрэл цахилгааны зардал		
210405	Цэвэр бохир усны зардал		
<b>210406</b>	<b>Бараа үйлчилгээний зардал</b>	<b>3,501,120,528.29</b>	<b>2,326,129,375.51</b>
210407	Бусад бараа үйлчилгээний зардал	123,779,506.05	151,185,416.34
210408	Жижиг эд хогшил худалдан авах зардал /Бараа бүт худ/авах		
210409	Банкны үйлчилгээний хураамж	461,316.59	-
210410	Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэ ажил, үйлчилгээний төлбөр	288,074,689.00	616,317,367.00
210411	Бусад зардал		
210412	Элэгдлийн зардал	13,115,781.72	9,341,195.90
210413	Барилга байгууламж /цэцэрлэгийн барилгын дулаалга, гэр хорооллын өрхийн байшингийн дулаалгатай холбоотой зардлууд/	2,515,511,578.75	1,469,660,978.51
210414	Бусад тоног төхөөрөмж /цахилгаан халаагуур, нийслэлийн агаарын бохирдлыг буурууллах газарт программ хангамж/	560,177,656.18	79,624,417.76
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>3,860,637,144.55</b>	<b>2,601,617,320.14</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(813,581,215.43)</b>	<b>(608,054,970.65)</b>
14	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз	89,149,477.52	3,799,758.8
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>89,149,477.52</b>	<b>3,799,758.88</b>
	Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз	15,669,723.00	
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>	<b>15,669,723.00</b>	
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>(740,101,460.91)</b>	<b>(604,255,211.77)</b>

### 3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,047,055,929.12</b>	<b>1,996,295,629.49</b>
120001	Улсын төсвөөс		
120004	Бусад байгууллагаас Олон улсын байгууллагын санхүүжилт	3,035,188,495.64	1,986,039,395.22
120005	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		7,207,954.27
120002	Хүүгийн орлого	11,867,433.48	2,733,280.00
120003	Тендерийн орлого		
120006	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		315,000.00
<b>2132</b>	<b>Бараа, үйлчилгээний урсгал зардал</b>		
	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>359,516,616.26</b>	<b>275,487,944.63</b>
210401	Цалин	320,945,630.26	220,950,925.77
210402	Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	38,570,986.00	54,537,018.86
210403	Тогтмол зардал		
210404	Гэрэл цахилгааны зардал		
210405	Цэвэр бохир усны зардал		
<b>210406</b>	<b>Бараа үйлчилгээний зардал</b>	<b>124,240,822.64</b>	<b>151,185,416.34</b>
210407	Бусад бараа үйлчилгээний зардал	123,779,506.05	93,342,040.00
210408	Гадаад томилолтын зардал		57,354,438.39
210409	Банкны үйлчилгээний хураамж	461,316.59	488,937.95
210410	Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	288,074,689.00	616,317,367.00
210411	Бусад зардал		
210413	Барилга байгууламж /цэцэрлэгийн барилгын дулаалга, гэр хорооллын ерхийн байшингийн дулаалгатай холбоотой зардлууд/	2,515,511,578.75	1,469,660,978.51
210414	Бусад тоног төхөөрөмж /цахилгаан халаагуур, нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газарт программ хангамж/	560,177,656.18	79,624,417.76
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)</b>	<b>3,847,521,362.83</b>	<b>2,592,276,124.24</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>(800,465,433.71)</b>	<b>(595,980,494.74)</b>
<b>14</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>		
145001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз(бодит)	89,149,477.52	3,799,758.88
145002	Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз	15,699,723.00	
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII)</b>	<b>(726,985,679.19)</b>	<b>(592,180,735.87)</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,687,663,018.96	<b>960,677,339.77</b>
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>960,677,339.77</b>	<b>368,496,603.90</b>

### 3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2017 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл</b>	-		<b>1,746,580,074.28</b>	<b>1,746,580,074.28</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Залруулсан үлдэгдэл</b>			<b>1,746,580,074.28</b>	<b>1,746,580,074.28</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			(740,101,460.91)	<b>(740,101,460.91)</b>
<b>2018 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл</b>			<b>1,006,478,613.37</b>	<b>1,006,478,613.37</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Залруулсан үлдэгдэл</b>				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			(604,255,211.77)	<b>(604,255,211.77)</b>
<b>2019 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл</b>			<b>404,956,681.60</b>	<b>404,956,681.60</b>

### 3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,505,549,500.00</b>	<b>2,592,276,124.24</b>	<b>913,273,375.76</b>	<b>73.9</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,168,589,500.00</b>	<b>1,042,990,727.97</b>	<b>125,598,772.03</b>	<b>89.2</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,168,589,500.00</b>	<b>1,042,990,727.97</b>	<b>125,598,772.03</b>	<b>89.2</b>
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,662,200.00	13,201,760.00	2,460,440.00	84.2
Тэтгэврийн даатгал	15,662,200.00	13,201,760.00	2,460,440.00	84.2
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>946,627,300.00</b>	<b>878,603,551.63</b>	<b>68,023,748.37</b>	<b>92.8</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	946,627,300.00	878,603,551.63	68,023,748.37	92.8
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>206,300,000.00</b>	<b>151,185,416.34</b>	<b>55,114,583.66</b>	<b>73.2</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	206,300,000.00	151,185,416.34	55,114,583.66	73.2
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,336,960,000.00</b>	<b>1,549,285,396.27</b>	<b>787,674,603.73</b>	<b>66.2</b>
Барилга байгууламж	2,256,960,000.00	1,469,660,978.51	787,674,603.73	65.1
Тоног төхөөрөмж	80,000,000.00	79,624,417.76	375,582.24	99.5
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,505,549,500.00</b>	<b>2,000,095,388.37</b>	<b>1,505,454,111.63</b>	<b>57.1</b>
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>3,505,549,500.00</b>	<b>2,000,095,388.37</b>	<b>1,505,454,111.63</b>	<b>57.1</b>
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		7,207,954.27		
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,505,549,500.00	1,986,039,395.22	1,519,510,104.78	56.7
Бусад орлого		6,848,038.88		
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>960,677,339.77</b>		
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>368,496,603.90</b>		





